



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2024.05.31

		Гүйцэтгэлийн түвшин						
Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хүрсэн түвшин /Биелэлт/	Биелэлтийн хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.								
/“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/								
Зорилт1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.								
1.1.	Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо	48 248	56 748	I-IV улирал	Хүсэлт гаргасан иргэдэд эхний хагас жилийн байдлаар 5816 иргэнд тоон гарын үсэг олгосноос 3437 иргэний үнэмлэх, 2379 мобайл аппкейшнээр олгож ажилласан болно.	100%
1.2.	Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим машинаар /КИОСК/ үзүүлэх	-	Улсын бүртгэлийн цахим /КИОСК/ машины тоо	3	6	IV улирал	Аймгийн төвийн нэг цэгийн үйлчилгээнд 24/7 киоск машин байршуулсан.	80%
			Киоск машинаар үйлчилгээ авсан бүртгэлийн тоо	5535	10 000	I-IV улирал	Эхний хагас жилийн байдлаар киоск машинаас 2341 иргэн үйлчилгээ авсан байна.	80%
1.3.	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх	-	Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо	0	2	I-IV улирал	Тус хэлтсийн иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нарын иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд улирал тутам өгөгдлийн шинжилгээ хийж ажлын ачаалалыг тэнцвэржүүлэн ажиллаж байна. Хэлтсийн нэгжийн зохион байгуулалтаар төвийн 4 улсын бүртгэгч 2 нь мэдүүлэг хүлээн авах, 2 нь боловсруулалт хийж, хэлтсийн даргаар батлуулсан ажлын хуваарийн дагуу сар сараар солигдож ажилладаг. 2024 оны	100%

							эхний 1,2,3-р сарын 25-ны хүртэл үйлчилгээ үзүүлсэн тоон судалгаанаас харахад эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ өсөх хандлагатай байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг Баян-Өлгий аймгийн хэмжээнд Алтай, Алтанцөгц, Дэлүүн, Улаанхус, Цагааннуур сум зэрэг 5 сумаас үзүүлж байгаа хүн амын тооноос хамааран бүртгэлийн тоо өөр өөр байна.	
1.4	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэж, түгээх	-	Хэвлэл мэдээлэл болон цахимаар олон нийтэд сурталчилсан тоо	20	32	I-IV улирал	Эхний хагас жилийн байдлаар тус хэлтсээс хэвлэл мэдээлэл болон цахимаар олон нийтэд сурталчилсан нийт тоо 13 байна. Үүнд: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр орон нутгийн радиод 4 удаа Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 6 удаа ярилцлага өгч ажилласан байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ХХК цахимаар болон биечлэн ирж бүртгүүлэх талаар контент бэлдэж, мэдээллийг фейсбук, социал сүлжээгээр олон нийтэд түгээн ажиллав. Засгийн “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд аймагт зохион байгуулагдсан удирдах ажилтны сургалтад оролцож мэдээлэл хийж орон нутгийн радиод ярилцлага өгч малчид иргэдийг мэдээллээр хангаж ажилласан. Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан Улсын бүртгэлийн байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх, бүртгүүлэхээр мэдүүлж байгаа эрхийн нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв, тогтоосон	100%

							хугацаанд мэдүүлэх, бүртгүүлэх үүрэг болон МУИХ-ын сонгуулийн тухай хууль болон иргэний шилжилт хөдөлгөөнийг бүргэлийг түр зогсоохтой холбоотой Хяналтын улсын байцаагч орон нутгийн радио, телевизд 3 удаа мэдээлэл хүргүүлсэн.	
			Контентын тоо	0	1	III-IV улирал	ДӨТ /КИОСК/ машины үйлчилгээний болон Хуулийн этгээдийн чиглэлээр ХХК хэрхэн байгуулах, цахимаар болон биечлэн ирж бүртгүүлэх, Үндэсний энгийн гадаад паспортыг алслагдсан сумдаас захиалах зэрэг 3 видео, контент хийсэн.	100%
Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.								
2.1.	“Улсын бүртгэлийн үйлчилгээний төв болон нэг цэг”-ийн үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллагын тусламж дэмжлэг	Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр үзүүлсэн үйлчилгээний тоо	0	20	I-IV улирал	Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр тус аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байрны Аж ахуйн үйлчилгээнд хорих ял эдэлж байгаа 2 иргэнийг тоон гарын үсэгт хамруулсан.	%
			Нэг цэгийн тоо 24/7	0	1	III-IV улирал	Аймгийн төвийн Төрийн үйлчилгээний нэгдсэн цогцолборын үйлчилгээний зааланд улсын бүртгэлийн 24/7 ДӨТ машинаас 260 лавлагаа авсанаас гадна үндэсний энгийн гадаад паспорт, цахим үнэмлэх, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн хураамжийг банкны карт ашиглан төлж байна. Мөн 24/7 ДӨТ машинаас шөнийн цагаар 2 иргэн бүртгэлийн үйлчилгээ авсан байна.	100%
			Бусдаар гүйцэтгүүлэх үйлчилгээ	0	0		Хамтын ажиллагааны хүрээнд нийт 4 удаа уулзалт зохион байгуулсан ба тойргийн нотариат, арилжааны банкуудтай, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтнүүдтэй, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын	

							газартай, аймгийн ЭМГ-ын холбогдох мэргэжилтнүүд болон сумын ЭМТ-ийн эрхлэгч нарт уулзалт зохион байгуулсан.	
2.2	Улсын бүртгэлийн хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтөлнө	-	Иргэний улсын бүртгэл хөтөлсөн тоо	39 688	69 500	I-IV улирал	Иргэний улсын бүртгэлд 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 14382 иргэн хамрагдсанаас: Төрсний бүртгэл 999, хүүхэд үрчлүүлсний 52, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 25, эцэг, /эх/ тогтоосны 10, гэрлэсний 173, гэрлэлт дуусгавар болсны 30, нас барсны 251, иргэний үнэмлэх олголтын 2278, үндэсний энгийн гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэх 6, түүнийг орлох бичиг баримтийн олголт 4531, биеийн давхцахгүй өгөгдлийн 1915, шилжилт хөдөлгөөний бүртгэлд 1025, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 439 иргэн, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр гэрчилгээ дахин олголтыг 199, нөхөн бүртгэлд 127 иргэн тус тус бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд нийт 2992 лавлагаа олгосон ба иргэнд 2327, албан хэрэгцээнд 131, хууль хяналтын болон төрийн байгуулагаад албан тоотоор 534 лавлагааг тус тус олгосон байна.	100%
			Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн тоо	9310	16 310	I-IV улирал	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлд хагас жилийн байдлаар нийт 2576 мэдүүлэг, онлайн 8 мэдүүлэг тус тус хүлээн авч хянан шийдвэрлэсэн. Арилжааны банкуудаар дамжуулан олгосон нийтдээ 1661 барьцааны гэрээ бүртгэсэн ба барьцаалбартай барьцааны гэрээ 309, барьцаалбаргүй барьцааны гэрээ 398 барьцаалбартай барьцааны	

							гэрээнд өөрчлөлт оруулах 36, барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 78, барьцааны гэрээ дуусгавар болгох 840, МИК-аас барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэл онлайнаар 8, бүртгэж баталгаажуулсан байна. Тайлангийн хугацаанд 244 бүртгэлд өөрчлөлт оруулсан ба эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 140 тус тус бүртгэж баталгаажуулсан байна.	
			Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн тоо	876	1520	I-IV улирал	Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 658 бүртгэл хийсэн байна. Үүнд: Шинээр бүртгэсэн ТБАГ 6, ХХК 92, ТББ 16, Хоршоо 44, Нөхөрлөл 2, Сан 1, Салбар 2, Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 154, дахин гэрчилгээ 64, нэрийн баталгаажуулалт 221 байна. Хуулийн этгээдийн татан буугдах 1 бүртгэл бүртгэсэн. Тамга, тэмдгийн хяналтын 233 дугаар олгож, оноосон нэр өөрчлөгдсөн болон ашиглалтын шаардлага хангаагүйн улмаас дахин тэмдэг хийлгүүлэх хүсэлтээр 56 тэмдэг хурааж авсан.	
2.3	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia, E-business/ -аар үзүүлэх бүртгэлийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	-	Цахимаар үзүүлсэн улсын бүртгэлийн тоо	1143	2200	I-IV улирал	Өнөөдрийн байдлаар www.e-mongolia.mn веб сайтаар захиалсан гадаад паспорт 90, иргэний цахим үнэмлэх 161 ширхэг хэвлэгдэн ирж иргэдээд олгогдоод байна.	80%
2.4	Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх /blockchain/	-	Цахим хэлбэрээр олгосон газар өмчлөх эрхийн болон үл хөдлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний тоо	0	5	III-IV улирал	Тайлангийн хугацаанд 46, газар өмчлөх эрхийн бүртгэл газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл 140 шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэлийг 35 тус тус бүртгэж эрхийг нь баталгаажуулсан байна.	100%

							Тайлангийн хугацаанд нийтдээ 311 өмчлөх эрх шилжих гэрээ бүртгэж баталгаажуулсан бөгөөд худалдах худалдан авах гэрээ 183, бэлэглэх гэрээ 48, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 45, шүүхийн шийдвэрээр 1, арилжих гэрээ 3, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 30 бүртгэл бүргэж баталгаажуулсан байна.	
2.5.	Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах, өөрчлөлт оруулах, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх	-	Газар, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дундын мэдээллийн сан үүсгэж, өөрчлөлт оруулсан тоо	3000	4000	I-IV улирал	Эд хөрөнгийн хаягийн бүртгэлийн зөрчилтэй 140 тус тус бүртгэж баталгаажуулсан байна.	90%
2.6	Иргэний улсын бүртгэлийн баримтыг цахимжуулах	-	Архивын тодорхойгүй төлөвт байгаа эх нотлох баримтыг цахимжуулсан тоо	890	1700	I-IV улирал	Архивын тодорхойгүй төлөвт байгаа 2008-2009 онд төрсөн 800 гаруй иргэний эх нотлох баримтыг цахимжуулсан. Тайлант хугацаанд 8810 бүртгэлийн 18452 хуудас материалыг цахимжуулсан.	100%
Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.								
3.1.	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100	100	I-IV улирал	Тус хэлтсийн Хяналтын улсын байцаагч нийт 12020 бүртгэлд байнгын хяналт тавьж, 6350 бүртгэлийг шалгасан болно. Үүнд: Иргэний улсын бүртгэлийн 6123 бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 3072 бүртгэл, Хуулийн этгээдийн 505 бүртгэл, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 2320 бүртгэлийн эх нотлох баримтад байнгын хяналт тавьж шалгасан	100%

							<p>болно. Хяналт шалгалтаар илэрсэн 116 бүртгэлийн зөрчлийг зөрчлийг таслан зогсоож, арилгуулах арга хэмжээ авч нийт 40 бүртгэлийг хүчингүй болгосон, зөрчил арилгах тухай 19 дүгнэлт тус тус үйлдсэн байна. Нийт 1541 иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлд холбогдох 90 дүгнэлт үйлдсэн байна. Бүртгэлийн зөрчлийг арилгуулах тухай 8 албан шаардлага, 1 мэдэгдэл хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан болно. Тус хэлтэси гаргасан 216 иргэн, хуулийн этгээдийн өргөдөл хүсэлт, 2 иргэний гомдлыг хүлээн авч хууль журмын дагуу шийдвэрлэж хариу өгсөн байна.</p> <p>Мөн Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн иргэн хуулийн этгээдийг хуулийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй, тогтоосон хууль, журам зөрчсөн буюу Зөрчлийн тухай хуульд заасан нийт 56 иргэн хуулийн этгээдийн гаргасан зөрчлийг шалган шийдвэрлэсэн, 2895000 төгрөг торгуулийг бүрэн төлүүлсэн Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлт хангуулан ажилласан байна.</p> <p>Улсын бүртгэлийн байгууллагыг төлөөлж 14 шүүх хуралд хариуцагчаар орж, үүсгэсэн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн болно.</p>	
3.2.	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй	-	Хугацаандаа байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо	156	159	I-IV улирал	Хэлтсийн төсөв, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах, байгууллага, иргэдэд нээлттэй байлгах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст 2024 онытөсөв	100%

	зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах, санхүүгийн дотоод аудитыг хэрэгжүүлэх						болон орлого, зарлага, төсвийн байгууллагын санхүүжилтийн 1-5 дугаар сарын мэдээнүүдийг хуулинд заасан хугацаанд шилэн дансанд байршуулсан.	
			Тайлагнасан мэдээллийн мөнгөн дүн	861949367, 13	103865030 0		Тус Хэлтэс нь батлагдсан төсвийн хүрээнд хяналттай үр ашигтай, хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 оны эхний 5 сарын байдлаар улсын төсвөөс 487.161.900 төгрөг, нэмэлт санхүүжилтээр УБЕГазраас УИХ-ын сонгуулийн бэлтгэл ажилд 32.174.800 төгрөг, Аймгийн ЗДТГазраас 10.892.250 төгрөг, нийт 530,228,950 төгрөгийн санхүүжилт авснаас 479.756.919 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан ба энэ нь нийт төсвийн 90.4% байна. Мөн тайлант хугацаанд 71.666.6 666 төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй байсанаас 87.733.174,5 төгрөгийн орлого оруулж, Сангийн Яам Улсын Төсөвт 82.300.343 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн болно. Орлогын төлөвлөгөөг 115%-иар биелүүлсэн болно.	
3.3.	Үндэсний аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх	-	Зөвлөмж, акт, албан шаардлагын тоо, биелэлтийн хувь.	0	0	I-IV улирал	Хэлтсийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд төрийн аудит хийлгэж, ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй мөн албан шаардлага акт тавигдаагүй ба “Зөрчилгүй” гэсэн дүгнэлт авсан.	100%
3.4.	Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хийх	-	Эрсдэлийг бууруулсан тоо	0	4	I-IV улирал	Хэлтсийн 2024 оны Эрсдэлийн төлөвлөгөөг батлан, төлөвлөгөөний дагуу ажиллаж биелэлтийг хугацаанд гаргаж УБЕГ-ын Бодлого, төлөвлөлт дүн шинжилгээний газарт хүргүүлэн ажиллаж байна.	100%

3.5.	Мэдээллийн санг ашиглаж буй албан хаагчдын компьютерт хортой кодын эсрэг хамгаалах программ суулгах	-	Программ суулгасан компьютерийн тоо	0	36	III улирал	Хэлтсийн мэдээлэл технологийн ажилтаны Компьютерт хортой кодын эсрэг хамгаалах программ суулгах хуваарийн дагуу сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөн ажиллаж байна.	
Зорилт 4. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.								
4.1.	МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах.	-	Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	I-II улирал	МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө болон хэлтсийн төлөвлөгөөнд заасан ажлыг тухай бүр хийж гүйцэтгэн илтгэх хуудсаар холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.	100%
4.2.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах	-	Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	I-III улирал	Хууль, журам, чиглэл, төлөвлөгөөг мөрдөн ажиллаж байна.	
Зорилт 5.Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.								
5.1.	Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.	Төсөл, хөтөлбөр	Гадаадад туршлага судалсан, сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	0	1	I-IV Улирал	УБЕГазрын 2024.05.06-ны өдрийн 2/6032 тоот албан бичгээр БНСУ-д зохион байгуулагдах “Хүртээмжийн манлайлал” сургалтад хувийн зардлаар суралцах тухай саналыг нийт албан хаагчдад танилцуулсан ба өөрийн зардлаар хамрагдах боломжтой албан хаагч байхгүй тухай мэдэгдсэн болно.	

5.2.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх.	ADB төсөл	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн сумдын тоо	5	8	III-IV улирал	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг Баян-Өлгий аймгийн хэмжээнд Алтай, Алтанцөгц, Дэлүүн, Улаанхус, Цагааннуур сум зэрэг 5 сумаас үзүүлж байгаа хүн амын тооноос хамааран бүртгэлийн тоо өөр өөр байна. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд үлдсэн Булган, Буянт, Бугат, Баяннуур сумуудад эд хөрөнгийн бүртгэлийн эрх, мөн эрх зүйч мэргэжилтэй 10 сумын улсын бүртгэгчид хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эрхийг нээлгэж шат дараатай бүртгэл хөтлүүлж эхэлсэн.	100%
5.3.	Гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх		Гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн сумдын тоо	0	2	III-IV улирал	Төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд аймгийн төвөөс алслагдсан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх үүднээс Булган, Цэнгэл, Ногооннуур, Дэлүүн сумдад үндэсний энгийн гадаад паспортын үйлчилгээ үзүүлэх эрхийг улсын бүртгэгч нар нээлгүүлэн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг тухайн сумын иргэдэд үзүүлэн ажиллаж байгаа ба тайлант хугацаанд 637 иргэний үндэсний энгийн гадаад паспортаа захиалгыг хүлээж авсан байна.	100%
5.4	Аймаг сумдын ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах		Шийдвэрлүүлсэн тоног төхөөрөмжийн тоо	4	6	I-IV Улирал	24/7 үйлчилгээний Дөт машиныг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлж Нэг цэгийн үйлчилгээний танхимд суурилуулан үйлчилгээ, хэрэглээнд оруулсан, одоо хэвийн ажиллаж байна.	100%
			Уулзалт зохион байгуулсан тоо	5	9		Цагааннуур боомтын удирдлага, албан хаагчдад Улсын бүртгэлийн шинэ үйлчилгээний болон гадаад паспорт, иргэний бичиг баримтыг хэрхэн шалгах, гэмт хэрэг зөрчлөөс	

						<p>урьдчилан сэргийлэх, мөн аймгийн ЭМГ-ын холбогдох мэргэжилтэнүүд болон сумдын ЭМТөвийн эрхлэгч, өрхийн эмнэлгүүдийн эрхлэгч, аймгийн төрөх тасгийн эмч, сувилагч нарт дундын мэдээллийн сангаар олгогдож байгаа регистрийн дугаар, төрөлтийн бүртгэлийн СТ-4 маягт, нас баралтын бүртгэлийн АМ-7 маягт олгох явцад гарч буй зөрчлийн талаар, Өлгий сумын ЗДТГ-ын ажлын албаны шуурхай хуралдаанд тус сумын хаягийн мэдээлэл болон иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний талаар Ногооннуур сум, Алтанцөгц сум, Буянт сум, Бугат сумын улсын бүртгэгч нар иргэддээ нээлттэй уулзалт зохион байгуулж мэдээллээр хангаж ажилласан. Мөн Орон нутгийн төрийн байгууллагуудтай уялдаа холбоог сайжруулах, иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээнд салбар дундын хууль эрх зүйд холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангаж төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх үүднээс Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтнүүдтэй харилцан мэдээлэл солилцож эд хөрөнгийн хаяг, нэгж талбарын дугаарын өөрчлөлт, кадастрын зөрүү, газар өмчлөх эрхийн өмчлөх эрх дуусгавар болох, сумдын улсын бүртгэгч нар газрын даамалуудтай хамтран ажиллах, хамтарсан сургалт зохион байгуулах зэрэг бусад асуудлаар харилцан тохиролцож ажиллахаар болсон.</p>
Зорилт 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.						

6.1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	-	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо	4	5	I-IV Улирал	Аймгийн Засаг даргын Тамгын газраас санаачлан Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлигын эсрэг хууль, тогтоомжийн талаар эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ЭБАТ-уудыг чадавхжуулах” сургалтыг Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн хурлын зааланд зохион байгууллаа. Тус сургалтад аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний хэлтэс, агентлагуудын удирдлагууд, сумдын удирдлагууд болон Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдах албан тушаалтнууд, байгууллагын ХАСХОМэдүүлэг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнууд хамрагдав.	100%
			Аймгийн ЗДТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг хэлтсийн хэмжээнд зохион байгуулсан тоо	3	5		“ЦАХИМД ХЭВШЬЕ” уриатай” ЦАХИМ ХӨГЖЛИЙН ӨДӨРЛӨГ” арга хэмжээнд оролцож, киоск машины хэрэглээг ард иргэдэд танилцуулсан. Иргэний эрх зүйн боловсролыг дэмжих үйл ажиллагааг сурталчлах зорилгоор Хуульчийн “Про боно” өдөрлөгт Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид оролцож иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан. Олон улсын Гэр бүлийн өдөр “Гэр бүлдээ гэрэл нэмье” аяны хүрээнд тус хэлтсийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран албан хаагчдын гэр бүл, үр хүүхдүүдэд чиглэсэн сургалт, гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран зохион байгуулсан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийн	

							үйл ажиллагаанд мөн Засгийн “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд аймагт зохион байгуулагдсан удирдах ажилтны сургалтад оролцож мэдээлэл хийсэн.	
Зорилт 7. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.								
7.1.	Хэлтсийн 2024 оны зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг батлаж, хэрэгжүүлэх	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	I-IV улирал	Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу тус хэлтсийн албан хаагч нарт улсын бүртгэлийн үйл ажиллагаанд эрсдийг бууруулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын /ахлах/ бүртгэгч нарт болзошгүй эрсдэлийг бууруулах мэргэжил арга зүйгээр хангах, тулгарч буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх, нэгдсэн ойлголт, зөвлөмж чиглэл өгөх, аливаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 10 удаа дотоодод, 5 удаа сургагч багш нараас хууль эрх зүйн сургалтыг тус тус зохион байгуулсан.	100%
7.2.	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системийг хэрэглээг нэмэгдүүлэх, холбогдох хуульд заасны дагуу мэдээллийг цахим хуудаст байршуулах.	Төслөөр	Цахим мэдээллийн хийсэн тоо сургалтын баяжилтыг	30	50	I- IV улирал	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системийг хэрэглээг нэмэгдүүлэх, холбогдох хуульд заасны дагуу мэдээллийг тухай бүр цахим хуудаст байршуулан ажиллаж байгаа ба Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын Хамтын ажиллагаа, сургалтын хэлтсээс ирүүлсэн бие даах хичээл үзэж, шалгалт өгсөн байдал 91%-тай байна.	100%

---oOo---

Төлөвлөгөөг үнэлсэн:

Төсвийн шууд захирагч

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга /С.АМУУАН/

/Д.ДЭЛГЭРСАЙХАН./

(албан тушаал)

(гарын үсэг)

(огноо)

(огноо)

Тэмдэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Нэгжийн дарга

(албан тушаал)

(гарын үсэг)

(огноо)

Тайлагнасан: нэгжийн дарга

Нэгжийн дарга


Хэлтсийн дарга

/Х.АМАНГҮЛ./

(албан тушаал)

(гарын үсэг)

(огноо)



2023.05.31

---oOo---